



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 10 сарын 21 өдөр

Дугаар A/65

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 434, 435 дугаар тогтоол, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 14, 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын ажил хүлээлцүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч

Б.Цэнгэл

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга

Нарийн бичгийн дарга

Б.Билгүтэ

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд:

Д.Отгонбаяр

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын ахлах шинжээч /зөвшилцсөнөөр/

А.Молор

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Д.Батболд

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн

Г.Ганболд

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн Захиргаа, удирдлагын газрын дарга

С.Сарантуяа

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн ерөнхий нягтлан бодогч

2. Ажлын хэсгийн удирдамжийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

3. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас тус ажлын хэсэгт орсон албан хаагчдын зардлын төсвийг 2 дугаар хавсралтаар баталсугай.


ТӨБЗГ тушаал-2022

132013335

4. Албан хаагчдын унаа, томилолтын зардлыг зохих журмын дагуу тооцож, дотоод томилолтын зардлаас гаргахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Н.Ганболд), Ерөнхий нягтлан бодогч (Ц.Гантуяа)-д хоёрдугаар хавсралтаар зөвшөөрсүгэй.

5. Гүйцэтгэх захирлын ажлыг 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс 10 дугаар сарын 27-ны өдөр хүртэл энэхүү тушаалын хавсралтад заасан удирдамжийн дагуу хүлээлцүүлж, үр дүнг танилцуулахыг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Б.Билгүтэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 21
-ны өдрийн 4/6 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

АЖИЛ ХҮЛЭЭЛЦҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН
АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Ажил хүлээлцүүлэх ажлын хэсэг нь дараах жагсаалтын дагуу материалыг шинээр томилогдсон гүйцэтгэх захиралд хүлээлгэн өгч, ажил хүлээлцүүлсэн акт үйлдэнэ.

1. Үйлдвэрийн газрын тамга, тэмдгийг хүлээлцэх;
2. Үйлдвэрийн газрын улсын бүртгэлийн гэрчилгээ болон бусад холбогдох бичиг баримтыг жагсаалт үйлдэж хүлээлцэх;
3. Үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийг /салбар, нэгжээр/ 2022 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийн байдлаар жагсаалтаар хүлээлцэх;
4. Харилцах банкны хуулга, кассын үлдэгдэл, авлага, өглөгийг 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар жагсаалтаар хүлээлцэх;
5. Гэрээ хэлэлцээр, холбогдох бусад баримт материалыг жагсаалтаар хүлээлцэх;
6. Гүйцэтгэх захирлын тушаал, шийдвэр, албан бичиг, архивын баримт бичгийг жагсаалтын дагуу хүлээлцэх;
7. Гүйцэтгэх захирлын нэр дээр бүртгэлтэй хөрөнгийн жагсаалт үйлдэн хүлээлцэх;
8. Шаардлагатай гэж үзсэн бусад материалыг жагсаалт үйлдэж хүлээлцэх.

Ажил хүлээлцүүлсэн тайланг 2 хувь боловсруулан 1 хувийг ажил хүлээн авсан тал, 1 хувийг ажлын хэсэг хадгална.

-----oOo-----

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/65 дугаар тушаалын 2 дугаар

БАТЛАВ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Б.ЦЭНГЭЛ

**ОРОН НУТАГТ ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ
ЗАРДЛЫН ТӨСӨВ**

Дархан-Уул аймаг дахь “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн даргын ажил хүлээлцэх албан ажлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын 2 жолооч 5 мэргэжилтний албан томилолтын зардлын төсөв.

Хугацаа: 10 дугаар сарын 24-ний өдрөөс 10 дугаар сарын 27-ны өдрүүдэд /хуанлийн 3 хоногоор/ хийж гүйцэтгэнэ.

Д/д	Зардлын төрөл	Төсөвлөсөн /төгрөгөөр/	Хянасан (төгрөгөөр)
1	2	3	4
1	Унааны зардал: Дархан-уул, аймаг явах ирэх унааны зардал $980 \text{ км} \times 2390 \times 0,25 = 585,550.00$	585,550.00	
2	Байр: $7 \text{ хүн} \times 3 \text{ хоног} \times 110000 = 2,310,000.00$ Хоол: $7 \text{ хүн} \times 3 \text{ хоног} \times 32000 = 672,000.00$	2,982,000.00	
	Нийт дүн:	3,567,550.00	

Тайлбар: Дотоод томилолтын зардлыг тооцохдоо Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дүгээр тушаалаар баталсан “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тушаалыг үндэслэв.

Танилцаж зөвшөөрсөн: Н.Ганболд /Захиргаа удирдлагын хэлтсийн дарга/

Төсөв хянасан: Ц.Гантуяа /Ерөнхий нягтлан бодогч/

Зардлын төсөв боловсруулсан: Г.Дэлгэрмаа /ТӨУЗХ-ийн мэргэжилтэн/

2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр